

**“НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ” ДУНД ХУГАЦААНЫ
ТӨЛӨВЛӨЛТИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ**

(Хяналт шалгалтын газар)

2025 оны 06 дугаар сарын 02

Улаанбаатар хот

Д/д	Бодлогын зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Батлагдсан төсөв	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)өссөн	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь	Хариуцах байгууллага
	1	2	3	4	5	6	7	8	9
1	9.5. Нийслэлийн хэмжээнд иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах орчны аюулгүй байдлыг хангахад чиглэсэн хотын стандарт, норм, дүрмийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, мөрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	9.5.3 Хотын стандартын дагуу орчны аюулгүй байдлын хяналт шалгалтыг сайжруулж, иргэдийн амьдрах орчны эрсдэлийг бууруулсан байна.	2021-2025	-	-	Хотын стандартын баримт бичиг	Нийслэлийн иргэдийн амьдрах орчны эрсдэлийг бууруулах, хотын стандарт, нормыг мөрдүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллав. Үүнд: - Барилгын түр хашааны стандарт хангаагүй, аюулгүй байдал алдагдсан 12 байршилд зөрчлийг арилгуулж, стандартыг мөрдүүлсэн. - Эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудын гадна орчны аюулгүй байдлыг хангуулах хүрээнд 20 эмнэлэгт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, 14 байгууллагад хугацаатай үүрэг өгсөн. Эдгээр байгууллагууд зөрчлийг 90 хувьтай арилгасан бөгөөд 6 эмнэлэг нь стандартын шаардлага хангасан байна. - Нийтийн эзэмшлийн явган хүний замын төлөв байдлыг шалгаж, 7 албан шаардлага хүргүүлэн засварын үүрэг даалгавар өгсөн. Орц, гарц гаргасан 2 аж ахуйн нэгжид Зөрчлийн тухай	100	НХШГ

1	2	3	4	5	6	7	8	9
						хуулийн дагуу нийт 10 сая төгрөгийн торгууль ногдуулсан. - Ахуйн хог хаягдлын тээвэрлэлт, нийтийн эдэлбэр газар, гудамж, зам талбайн цэвэрлэгээ эрхлэгч 20 аж ахуйн нэгжийн 298 тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, 17 зогсоол, 17 засварын байр зэрэгт хяналт шалгалт хийж, 214 зөрчил илрүүлэн, 179 заалт бүхий 20 албан шаардлага хүргүүлж, биелэлтэд хяналт тавин ажиллаж байна. - Хүн амын нягтаршил ихтэй бүсэд байрлах 23 аж ахуйн нэгжийн 49 ШТС, 4 АХЦС-ыг хамруулсан хяналт шалгалт хийв. Объектуудын 55% нь стандартын дагуу гадна ариун цэврийн байгууламжтай, 2.8% нь нүхэн жорлон ашиглаж байсныг буулгуулж, UCS1401B:2022 стандартад нийцсэн ариун цэврийн өрөөтэй болох хугацаатай шаардлага хүргүүлсэн. 60-аад ШТС, АХЦС-ын өнгө үзэмжийг сайжруулах, будгийн сэргээн засварын ажлыг хийж гүйцэтгэсэн. - Хотын стандарт, нормын хэрэгжилтийг хангах хүрээнд нийт 55 байршилд хороо, эрүүл мэндийн төвийн ариун цэврийн өрөөний тоноглол, гадна налуу зам, явган зам, тохижилт, чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж, цэцэрлэгийн гадна хашаа зэрэг байгууламжийг хотын стандартын шаардлагыг хангуулан ашиглалтад оруулсан. Чийрэгжүүлэлтийн талбай, явган замын тохижилтын ажилд аюулгүй байдлыг хангах заавар, тэмдэглэлийг Монгол хэлээр		

	1	2	3	4	5	6	7	8	9
							байршуулж, иргэдийн хүртээмжийг нэмэгдүүлэв.		

ТАНИЛЦСАН:
ГАЗРЫН ДАРГА

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

ДОТООД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА

НЭГТГЭСЭН:
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ, ТАЙЛАН
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

С.ЭНХБАЯР

Б.БАЙГАЛМАА

Б.ОЮУНТУЯА

М.ГАЧМАА

